



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2018 оны 12 сарын 28-дөр

Дугаар А/545

Улаанбаатар хот

Заавар шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нярайд үзүүлэх тусламж, үйлчилгээний заавар"-ыг нэгдүгээр, "Нярайн шилжүүлгийн маяг"-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Тушаалыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /М.Баттүвшин/-т даалгасугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Я.Амаржаргал/-т даалгасугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны "Нярайн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах тухай" 02 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



Д.САРАНГЭРЭЛ

080626

Эрүүл Мэндийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 1/545 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

## Нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний заавар

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нярайд төрөх үед болон төрсний дараа үзүүлэх эмнэлзүйн нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээг Эрүүл мэндийн байгууллага цаг хугацаанд нь чанартай, аюулгүй, үр дүнтэй үзүүлнэ.

1.2. Энэхүү заавар нь нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт, нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлгийн мэргэжилтний чиг үүрэг, нярайн тусламж, үйлчилгээний нөөцийг багтаасан болно.

### Хоёр. Нярайн эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалт

#### 2.1 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд

Харъяаллын нутаг дэвсгэрийн нярайн эрүүл мэндийн байдлыг үнэлэх, хянах, эрүүл өсөж бойжихыг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, сувилах эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлнэ.

2.1.1 Жирэмсэн эмэгтэйчүүдэд төрөх үед болон төрсний дараа нярайд үзүүлэх нэн шаардлагатай тусламж, хөхөөр хооллолт, нярайн асаргаа сувилгаа, "Имж эх" асаргаа зэргийг зааж сурган, эхийн хэвийн амаржих сэтгэл зүйн бэлтгэлийг хангана.

2.1.2 Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төв нь нярайд 2 сар хүртэлх хугацаанд 6-аас доошгүй удаа (эхний сард 4 удаа, 2 дахь сард 2 удаа) гэрийн эргэлт хийж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Үйлчилгээ үзүүлсэн тэмдэглэлийг эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэрт бичиж баталгаажуулна.

2.1.3 Сум, тосгоны ортой эмнэлэгт "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж"-ийг үзүүлнэ.

2.1.4 Лавлагаа шатлалын эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай нярайд холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, шилжүүлэх, эргэх холбоо тогтоох, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

2.1.5 Жирэмсэн болон төрсний дараах үед үзүүлэх журмын дагуу жирэмсэн эмэгтэйг хянах, эх, урагт эрсдэл илэрсэн үед мэргэжлийн эмчийн зөвлөгөө авна.

2.1.6 Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж", эрсдэлтэй ба өвдсөн нярайд эрт илрүүлэх, оношлох, чадварыг эзэмшсэн байна.

#### 2.2 Аймаг, дүүргийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нийслэлийн амаржих газрууд

##### 2.2.1 Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн төрөх тасаг, Амаржих газарт

2.2.1.1 Тухайн эмнэлэгт төрж буй бүх нярайд эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ, "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж" үзүүлнэ.

2.2.1.2 Нярайн амилуулах тусламжийг багаар үзүүлнэ.

2.2.1.3 Амаржих газар нь үйлчлэх хүрээний харъяаллын дагуу төрсөн жирэмсний тээлтийн 32 долоо хоног ба түүнээс дээш тээлтийн настай, 1500 грамм ба түүнээс дээш жинтэй төрсөн дутуу нярай, халдварын ба халдварын бус эмгэгтэй нярайд амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлнэ.

2.2.1.4 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн тусламж үйлчилгээ шаардлагатай нярайд телемедицинээр зөвлөгөө авах, холбогдох эрүүл мэндийн байгууллагад илгээх, эргэх холбоо тогтоох, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.

2.2.1.5 Мэс заслын эмгэг, мэс заслаар эмчлэгдэх төрөлхийн хөгжлийн гажигтай, тухайн шатлалын эмнэлэгт эмчлэгдэх боломжгүй бол энэхүү тушаалын шилжүүлэх тээвэрлэх журмын дагуу шилжүүлэх ажлыг зохион байгуулна.

## **2.2.2 Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төвд**

2.2.2.1 Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо эмчилгээний төв нь харъяаллын нутаг дэвсгэрт оршин буй нярайд амбулаторийн ба хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлнэ.

2.2.2.2 Дүүргийн нэгдсэн эмнэлгийн "Нярайн кабинет" нь харъяаллын нутаг дэвсгэрт оршин буй нярайг үзэж зөвлөгөө өгөх ба гүйцэд төрсөн нярай, тээлтийн нас 35 - 36 долоо хоногтой төрсөн хожуу дутуу нярайн зонхилон тохиолдох (амьсгалын замын өвчин, суулгалт, шарлалт, арьсны халдвар, тархины эмгэгшил г.м.) эмгэгийг дүүргийн нэгдсэн эмнэлгийн "Нярайн тасаг/палатад"-д хэвтүүлэн эмчилнэ.

2.2.2.3 Нярайн тасаг/палатад нярайн чиглэлээр мэргэшсэн хүүхдийн эмч, сувилагч ажиллана.

2.2.2.4 Эмнэлгийн мэргэжилтэн нь нярайд нэн шаардлагатай тусламж, амилуулах тусламж үзүүлэх чадвартай байна.

2.2.2.5 Халдварын эрсдэлтэй болон халдвартай нярайг тусгаарлан хянаж, эмчилгээ хийнэ.

2.2.2.6 Анхан шатлалын эмнэлгийн эрүүл мэндийн ажилтнуудад эрүүл мэндийн тусламж үйлчилгээний мэргэжил аргазүйн зөвлөгөөг цахимаар өгөх ба орон нутагт нь очиж тусламж үйлчилгээ үзүүлнэ. Эмчилгээг лавлагаа шатлалын ба төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт үргэлжлүүлэхээр бол шилжүүлнэ.

2.2.3 Нярайн сэхээн амьдруулах эрчимт эмчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан эрчимт эмчилгээний 1-2 ортой байна

2.2.4 Нярайн эмч, сувилагч нь мэргэжлийн чиглэлээр сургалтанд хамрагдаж суралцсан байна.

## **2.3 Хүүхдийн төв сувилалд:**

2.3.1 Дутуу болон бага жинтэй нярайд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг хүүхдийн төв сувиллын дутуу, бага жинтэй нярайн торниулах тасагт үргэлжлүүлэн үзүүлнэ.

2.3.2 Амаржих газар, Нэгдсэн эмнэлэг, Төрөлжсөн эмнэлгээс нярайг хүлээн авах заалт;

2.3.2.1 Биеийн байдал тогтвортой;

2.3.2.2 Амьсгалаа түгжихгүй байгаа (сүүлийн 7 хоног);

2.3.2.3 Биеийн дулаанаа зохицуулах чадвартай;

2.3.2.4 Нярайн задгай орон дээр гараад багадаа 48 цаг болсон;

2.3.2.5 Хооллолтын бэрхшээлгүй, насандаа тохирсон сүүг хооллох бусад аргаар (тариур, аяга, угж) өгч байгаа болон хөхөөр хооллож байгаа;

2.3.2.6 Биеийн жин 3 өдөр дараалан өдөрт 15 граммаас багагүй нэмсэн;

2.3.2.7 1500 грамм хүртэлх жинтэй нярайг 1-2 долоо хоногтойд, 1750 гр хүртэлх жинтэй нярайг 1 хүртэлх долоо хоногтойд хүлээн авч торниулах болон сэргээн засах эмчилгээг хийж эхэлнэ.

## **2.4 Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг-Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд:**

- 2.4.1 Оношилгоо эмчилгээний өндөр технологи, төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламж шаардлагатай өвчтэй нярайд эмнэлгийн тусламж үйлчилгээг амбулаториор болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлнэ.
- 2.4.2 Шинээр төрж буй нярай бүрт "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж"-ийг үзүүлэх ба үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт амьдарч буй нярайд төрсний дараах үед эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.
- 2.4.3 Бусад эрүүл мэндийн байгууллагад нярайн төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээ үзүүлэх, мэргэжил арга зүйгээр хангах ба сургалт, судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхлэн явуулна.
- 2.4.4 Нярайн тусламж үйлчилгээ, нярайд тохиолдох өвчин эмгэгийн оношилгоо эмчилгээний стандарт, заавар боловсруулна.
- 2.4.5 Нярайн тусламж үйлчилгээний чиглэлээр эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж бэлтгэнэ.
- 2.4.6 Өндөр эрсдэлтэй эх, нярайг төрөх үед тусламж үйлчилгээг багаар үзүүлнэ.
- 2.4.7 Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ шаардагдах нярайн эмгэгүүд:
  - 2.4.7.1 Жирэмсний тээлтийн 32 долоо хоног хүрээгүй төрсөн, биеийн жин 1500 граммаас бага жинтэй төрсөн дутуу нярай
  - 2.4.7.2 Туйлын бага жинтэй дутуу нярай (1000 граммаас бага)
  - 2.4.7.3 Мэс заслын яаралтай тусламж шаардлагатай нярай
  - 2.4.7.4 Мэс заслын эмчилгээний өмнөх болон дараах үеийн тусламж үйлчилгээ
  - 2.4.7.5 Олон эрхтэн тогтолцооны хүнд эмгэг
  - 2.4.7.6 Амьсгалын дутагдлын хүнд хэлбэр
  - 2.4.7.7 Нярайн амьсгалын эмгэгээс шалтгаалсан уушгины архаг өвчнүүд
  - 2.4.7.8 Даамжрах явцтай уушгины артерийн даралт ихсэлт
  - 2.4.7.9 Тархи нугасны хүнд хэлбэрийн гэмтэл
  - 2.4.7.10 Нярайн хүчилтөрөгч цус дуталт тархины эмгэгшлийн хүнд хэлбэр
  - 2.4.7.11 Бөөрний цочмог дутагдал
  - 2.4.7.12 Олон эрхтний дутмагшил хавсарсан хүнд хэлбэрийн үжил
  - 2.4.7.13 Цөмөн шарлалт
  - 2.4.7.14 Гэдэсний үхжилт үрэвслийн >3 зэрэг
  - 2.4.7.15 Хавдар
  - 2.4.7.16 Төрөлхийн дархлаа дутмагшил
  - 2.4.7.17 Удамшлын, хромосомын, бодисын солилцооны хүнд эмгэгүүд
  - 2.4.7.18 Төрөлжсөн нарийн мэргэшлийн эмчийн тусламж үйлчилгээ шаардлагатай төрөлхийн хөгжлийн гажиг
- 2.4.8 Хэт дутуу, бага жинтэй төрсөн, хүнд өвчилсөн өндөр эрсдэл бүхий нярайн мэдрэл, сэтгэхүй, хөдөлгөөний хөгжлийг хянан.
- 2.4.9 Төрөлжсөн мэргэшлийн эмчийн тусламж үйлчилгээ шаардлагатай нярайд телемедицинээр, утсаар, дуудлагаар зөвлөгөө өгнө.

### **Гурав. Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж**

- 3.1 Төрөх үеийн тусламж үзүүлж байгаа аль ч шатны Эрүүл мэндийн байгууллага "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж"-ийг заавар, журмын дагуу үзүүлнэ.
- 3.1.1 Төрж буй эх ба нярай хүүхэд бүрт тусламж үйлчилгээг үзүүлэх дэмжлэгт орчинг бүрдүүлнэ.
- 3.1.2 Төрж буй нярай бүрт "Нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж"-ийг багаар (нярайн, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн, мэдээгүйжүүлэг, ерөнхий мэргэжлийн, сумын эмч, эх баригч, сувилагч, бусад шаардлагатай мэргэжлийн эмч) үзүүлнэ.

- 3.1.3 Нярайн оношилгоо эмчилгээний стандарт, удирдамж, зааврыг мөрдөж, тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.1.4 Нярайн эрүүл мэндийн талаар нотолгоонд суурилсан мэдээлэл зөвлөгөө өгнө.
- 3.1.5 Нярайд тусламж үйлчилгээ үзүүлж буй үед халдвар, хамгааллын дэглэмийг чанд баримтлана.
- 3.1.6 Нярайн нэн шаардлагатай тусламжид шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийг бүрдүүлж ажиллана.

### **3.2 Төрөх өрөөг бэлтгэх**

- 3.2.1 Төрөх өрөөний дулаан 24 хэмээс багагүй байх
- 3.2.2 Эх барихын иж бүрдэл, нярайн өлгий даавуу, малгай, хуурайшуулах даавуу, эх нярайг хучих дулаан хөнжил, хүйг хавчих, таслах хэрэгсэл бэлтгэх
- 3.2.3 Нярайн сэхээн амьдруулалтын хэсгийг (дулаацуулах ширээ, амьсгалуулах хүүдий, хошуувч, нэг удаагийн соруул, соруулах аппарат ажиллагаатай эсэхийг шалгах, хүчилтөрөгч болон хүчилтөрөгч өгөх гуурс, тохирох хэмжээтэй мөгөөрсөн хоолойн гуурсууд, тариур, эм бэлдмэл-эпинефрин, 0.9%-ийн натрийн хлорийн уусмал, 4%-ийн натрийн гидрокарбонатын уусмал) бэлтгэх

### **3.3 Төрсөн нярайд үзүүлэх тусламж**

- 3.3.1 Нярайн төрсөн цаг, минут, хүйсийг чангаар хэлнэ.
- 3.3.2 Нярайг төрмөгц эхийн хэвлий дээр хуурай даавуун дээр тавьж, эхний 5 секундээс удаахгүйгээр арчиж эхлэх, бүрэн хуурайшуулна, нойтон даавууг солино.
- 3.3.3 Нярайг хуурайшуулах явцдаа хүүхдийн биеийн байдлыг (гүйцэд болон дутуу нярай эсэх, ураг орчмын шингэн зунгагтай эсэх, өөрөө амьсгалж буй эсэх, зүрхний цохилт, булчингийн хүчдэл, арьсны өнгө) хурдан үнэлнэ.
- 3.3.4 Нярайн биеийн байдал сайн бол нүцгэнээр нь эхийн цээжин дээр тавьж арьс-арьсаар шүргэлцүүлнэ, нярайд малгай өмсгөн, толгойг хажуу тийш харуулж хэвтүүлнэ, эхийн цээжийг өндөрлөнө, эхтэй нь хамт дулаан хөнжлөөр хучина.
- 3.3.5 Ариун бээлийтэй гараар хүйн лугшилтыг шалгаж, хүйн лугшилт зогссоны дараа (1-3 минутад) ариун хуванцар хавчаараархүйн угаас 2 см зайтай хавчина, 2 дахьбагажийг эсвэл хавчаарыг эхний хавчаараас 3 см зайтай хавчиж, хүйг эхний хавчаарт ойрхон тасална.
- 3.3.6 Төрсний дараах эхний 1 ба 5 минутад нярайг Алгарын оноогоор үнэлнэ.
- 3.3.7 Хэрэв төрөлхийн хөгжлийн гажиг илэрсэн бол цаг хугацаанд нь удирдамж зааврын дагуу тусламж үзүүлнэ.
- 3.3.8 Нярайг хөхөө хайх, хөхөх оролдлого хийх шинж, дохио ажиглагдмагц хөхийг амлуулна.
- 3.3.9 Нярайн бугуйнд нярайн мэдээллийг бичсэн таних тэмдэг зүүнэ.
- 3.3.10 Төрөх орон дээр эхтэйгээ арьс-арьсаар шүргэлцэж буй нярайн хөхөө амалж хөхөж буй байдал, амьсгалын байдал, амьсгалын тоо, цээжний хонхолзолт, биеийн дулааныг 15 минут тутамд хянана.
- 3.3.11 Хөхийг бүрэн амлуулсны дараа 2 цагийн дотор нүдний халдвараас сэргийлэх, цусархаг өвчнөөс сэргийлэх тусламжийг үзүүлнэ.
- 3.3.12 Нярайн ам, хамраас соруулах, хүйнд эм тавих, ус болон бусад шингэн өгч амлуулах зэрэг халтай ажилбарыг хийхгүй.
- 3.3.13 Төрөх өрөөнд эхтэйгээ хамт 2 цаг болоод төрсний дараах тасагт шилжихийн өмнө нярайн биеийн жин, урт, толгойн тойрог, цээжний тойргийг хэмжинэ.
- 3.3.14 Нярайд яаралтай тусламж, эрчимт эмчилгээ шаардлагагүй бол төрсний дараах тасагт эхтэй нь хамт байлгаж хөхөөр хооллоно.
- 3.3.15 Нярайг дааруулахгүй, халууцуулахгүй, биеийн дулааныг 36.5 - 37.5°C хэмд байлгана.

- 3.3.16 Төрсний дараах эхний 24 цагийн дотор нярайд сэргийлэх тарилгуудыг хийнэ.
- 3.3.17 Гүйцэд нярайг төрснөөс хойш 24 цагийн дараа угааж, усанд оруулж болно.
- 3.3.18 Төрөх тасаг, амаржих газар нь нярайд түнхний мултрал ба дутуу хөгжил, сонсголын эмгэг, дутуу нярайн нүдний торлогийн эмгэг, бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийн тандалт шинжилгээ хийнэ /тухайн эмнэлэгт хийж буй/.

#### **3.4 Дутуу, бага жинтэй нярайд үзүүлэх нэмэлт тусламж**

- 3.4.1 Дутуу, бага жинтэй (1500 - 2500 гр) нярайг аль болох удаан арьс-арьсаар шүргэлцүүлнэ. Цаашид "Имж эх" асаргаагаар нярайг асарна.
- 3.4.2 Эх хүндрэлтэй төрсний улмаас хүүхдээ арьс-арьсаар шүргэлцүүлэх боломжгүй бол нярайг дулаан хучих эсвэл өлгийдөж дулаацуулах орон дээр тавина.
- 3.4.3 Маш бага жинтэй нярайд (1500 гр-аас бага) тусламж үйлчилгээ шаардлагатай тул инкубаторт авна. Биеийн халууныг 3 - 6 цаг тутам хянана.
- 3.4.4 Дутуу, бага жинтэй хөхөө хөхөж чадахгүй нярайг хөхөө хөхөх чадвартай болтол хооллох бусад аргаар зөвхөн хөхний сүүгээр хооллоно.
- 3.4.5 Дутуу, бага жинтэй нярайг усанд оруулахгүй, төрснөөс хойш 24 цагийн дараа чийгтэй алчуураар биеийг арчина.
- 3.4.6 Хэрэв нярайг цаашид сувилах, эмчлэх шаардлагатай бол нярайн хожуу үед нь /хөхөх залгих үйл ажиллагааны зохицуулга тогтворжсон үед/ тухайн байгууллагад баримтлах журмын дагуу шилжүүлж эмчилнэ.

#### **3.5 Нярайн амилуулах тусламж**

- 3.5.1 Нярай төрөөд амьсгалаагүй, булчингийн хүчдэлгүй, гэхдээ амьд төрөлтийн шинжүүд болох өөрөө амьсгалах, зүрх цохилох, хүйн судас лугших, булчин хөдлөх шинжүүдээс аль нэг нь илэрсэн бол сэхээн амьдруулах эмчилгээг төрсний дараах эхний 30 секундэд эхэлсэн байна.
- 3.5.2 Нярайн амьсгалыг өөрөө тэлэгддэг Амбу хүүдий эсвэл урсгалаар тэлэгддэг хүүдий, эсвэл "Т" холбогчтой гар ажиллагаатай аппаратаар удирдана.
- 3.5.3 Нярайн амьсгалыг 1 минутад 40 удаа байхаар удирдах ба үр дүнтэй удирдаж байвал зүрхний цохилтын тоо нэмэгдэнэ.
- 3.5.4 Ураг орчмын шингэн зунгагтай, булчингийн хүчдэл суларсан, амьсгалын зам зунгаагаар бөглөрсөн, өөрөө идэвхтэй амьсгалахгүй байгаа, үед амьсгалын замыг чөлөөлж соруулна.
- 3.5.5 Нярайн амьсгалыг 30 секунд удирдаад зүрхний цохилтыг үнэлнэ.
- 3.5.6 Хэрэв зүрхний цохилтын тоо нэг минутад 60-аас цөөн бол цээжний шахалт хийнэ, мөгөөрсөн хоолойд гуурс тавьж амьсгалыг удирдана. Цээжний шахалт, амьсгал удирдах харьцаа 3:1 байна. 30 секундын дараа дахин үнэлэхэд зүрхний цохилтын тоо 60-аас цөөн хэвээр бол хүйн хураагуур судсанд /гуурс тавьж/ эмийн эмчилгээ хийнэ.
  - 3.5.6.1 Эпинефрин 1:10000 уусмалаас 0.1-0.3 мл/кг тооцож, судсанд эсвэл 0.5-1.0 мл/кг тооцож мөгөөрсөн хоолойн гуурсаар хийнэ. Үр дүнгүй бол 3-5 минут тутамд зөвхөн судсанд давтан хийнэ. Эпинефрин өндөр тунгаар хийх нь нярайн тархи, зүрхийг гэмтээж болохыг санах.
  - 3.5.6.2 Эргэлдэх цусны эзэлхүүнийг нэмэх эмчилгээнд 0.9%-ийн натрийн хлор эсвэл рингер лактатын уусмалыг 10 мл/кг тооцож, аажим 5-10 минутын турш судсанд хийнэ.
  - 3.5.6.3 Хүнд хэлбэрийн бодисын солилцооны хүчилшилтэй, сэхээн амьдруулах эмчилгээ үр дүн муутай бол судсанд 4%-ийн натрийн гидрокарбонатын уусмал 4 мл/кг тооцож 2 минутаас багагүй хугацаагаар аажим шахаж хийнэ.
  - 3.5.6.4 Хэрэв зүрхний цохилтын тоо нэг минутад 60-100 бол амьсгал оруулах даралтыг бага зэрэг нэмнэ-илүү хүчтэй базна. 30 секундын дараа (төрсний

дараах 1 минут дах үнэлгээ) зүрхний цохилтыг дахин үнэлэхэд нэг минутад 100-аас цөөн хэвээр бол цээжний шахалт хийнэ. Зүрхний цохилтын тоо өсөхгүй буурч байвал эмийн эмчилгээ хийнэ. Хошуувчаар амьсгал удирдахад үр дүнгүй бол мөгөөрсөн хоолойд гуурс тавьж амьсгалыг удирдана.

- 3.5.6.5 Хэрэв зүрхний цохилтын тоо нэг минутад 100-аас дээш өссөн бол өөрийн амьсгалыг тогтвортой болтол амьсгалыг үргэлжлүүлэн удирдана.
- 3.6 Сэхээн амьдруулах эмчилгээ хийж буй нярайн тээлтийн нас 32 долоо хоногоос их, зүрхний цохилтын тоо нэг минутад 100-аас олон бол нэмэлт хүчилтөрөгчгүйгээр амьсгалыг удирдах ба зүрхний цохилт 100-аас цөөн эсвэл цөөрч байвал 30-40%-ийн хүчилтөрөгчтэй амьсгалыг удирдана. Зүрхний цохилтын тоо 60-аас цөөрвөл 100%-ийн хүчилтөрөгчтэй удирдана.
- 3.7 Сэхээн амьдруулах эмчилгээ хийж буй нярайн тээлтийн 32 долоо хоног хүрээгүй төрсөн, зүрхний цохилтийн тоо нэг минутад 100-аас олон бол 30-40%-ийн хүчилтөрөгчтэй амьсгалыг удирдах ба зүрхний цохилт цөөрч байвал 100%-ийн хүчилтөрөгчтэй амьсгалыг удирдана.

#### **Дөрөв. Нярайд эмнэлгийн тусламж үзүүлэх эмнэлгийн мэргэжилтнүүдийн чиг үүрэг**

- 4.1 Эх барихын эмч, эх баригч нар дараах тохиолдолд тусламж үзүүлнэ.
- 4.1.1 Төрөх өрөөнд нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үзүүлж, эрүүл төрсөн эх нярайг хянах
- 4.1.2 Шаардлагатай тохиолдолд нярайд амилуулах тусламж үзүүлэх
- 4.2 Нярайн эмч, сувилагч нар дараах тохиолдолд тусламж үзүүлнэ.
- 4.2.1 Дутуу төрөлт
- 4.2.2 Ихэр төрөлт
- 4.2.3 Том ураг
- 4.2.4 Ургийн бүтэлт
- 4.2.5 Төрөлхийн хөгжлийн гажигтай нярай
- 4.2.6 Төрөлтийн үйл ажиллагаа эхэлсэн үед ургийн хүчилтөрөгчийн дутмагшил илэрсэн
- 4.2.7 Хавсарсан эмгэгтэй эхийн төрөлт
- 4.2.8 Эхэс ховхрох
- 4.2.9 Төрөлтийн 2-р үе удаан үргэлжилсэн
- 4.2.10 Эх барихын ажилбарын төрөлт
- 4.2.11 Үр шилжүүлэн суулгасан
- 4.3. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн чиг үүрэг:
- 4.3.1 Эх, нярайн биеийн байдлын талаарх мэдээлэл цуглуулах (өмнөх болон одоогийн жирэмслэлт, төрөлт, жирэмсний хордлого г.м)
- 4.3.2 Нярайд үзлэг хийж тэмдэглэл хөтлөх (биеийн ерөнхий байдал, амин үзүүлэлтүүд, мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагаа, биемахбодын ба бүтэц үйл ажиллагааны хөгжил, эрхтэн тогтолцооны анатом-физиологийн ба эмгэг байдлын үнэлгээ, амьдралын чухал эрхтний алдагдлын үнэлгээ)
- 4.3.3 Нярайд эмнэлзүйн стандарт, удирдамж, зааврын дагуу тусламж үйлчилгээ үзүүлэх, протокол хөтлөх
- 4.3.4 Оношийг өвчний олон улсын ангиллын дагуу тавих
- 4.3.5 Нярайг тээвэрлэхээр бол (төрөх өрөөнөөс болон шатлал ахиулж) биеийн байдлыг тогтворжуулсны дараа тээвэрлэх
- 4.3.6 Нярайн асаргаа сувилгаа, эрүүл ахуй, сэргийлэх тарилгын талаар зөвлөгөө өгөх, сургах
- 4.3.7 Нярайд түнхний мултрал ба дутуу хөгжил, сонсголын эмгэг илрүүлэх тандалт шинжилгээ хийлгэх, Нярайн нүдний торлогийн эмгэг, бодисын солилцооны

төрөлхийн зарим эмгэгийн тандалт шинжилгээгцаг хугацаанд нь төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулж хийлгэх.

4.4.Эзэмших ур чадвар:

- 4.4.1 Нярайн биеийн байдлыг үнэлэх
- 4.4.2 Эх нярайн талаарх цуглуулсан мэдээлэлд үнэлгээ, дүгнэлт хийх
- 4.4.3 Төрөх үед болон төрсний дараа нярайд учрах эрсдэлт хүчин зүйлийг илрүүлэх
- 4.4.4 Нярайг төрсний дараа Апгарын үнэлгээ, амьсгалын дутагдлыг үнэлэх  
Сильверман, Доунсын үнэлгээ, биемахбодын хөгжлийн үнэлгээ, бүтэц үйл ажиллагааны үнэлгээ хийх
- 4.4.5 Төрөлхийн хөгжлийн гажиг болон мэс заслын эмгэгийг оношлон эмнэлзүйн стандарт, удирдамж, зааврын дагуу тусламж үзүүлэх
- 4.4.6 Нярайд онош тодруулах шинжилгээ, ажилбаруудыг үйлдлийн стандарт, удирдамжийг баримтлан хийх, үнэлгээ дүгнэлт хийх
- 4.4.7 Нярайд нэн шаардлагатай болон сэхээн амьдруулах тусламжийг эмнэлзүйн стандарт, удирдамж, зааврын дагуу үзүүлэх
- 4.4.8 Нярайн дулаан зохицуулга, хооллолт, нүүрс ус болон ус-эрдсийн солилцоо, хүчил суурийн хийн тэнцвэрлэмж, билирубины солилцоо, гомеостаз, удамшлын ба төрөлхийн бодисын солилцооны эмгэг, хавдар, мэс заслын өмнөх ба дараах эмчилгээг тооцож хийх, тэгшитгэх

4.5. Эзэмших мэдлэг:

- 4.5.1 Нярайн тусламж үйлчилгээний оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамж, эмнэлзүйн заавар
- 4.5.2 Нярайд хэрэглэх тусгай болон өндөр технологийн багаж тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах удирдамж, заавар
- 4.5.3 Өвчний олон улсын ангилал
- 4.5.4 Ураг, нярайн хөгжлийн физиолог ба эмгэг байдал
- 4.5.5 Төрлөгийн үеийн ургийн физиолог ба эмгэг байдал
- 4.5.6 Нярайн биемахбодын ба бүтэц үйл ажиллагааны өсөлт хөгжил
- 4.5.7 Нярайн дасан зохицох чадвар, шилжилтийн үеийн байдал
- 4.5.8 Нярайг тээвэрлэх зарчим
- 4.5.9 Нярайд хэрэглэж буй эм бэлдмэлийн фармакокинетик, фармакодинамик

4.6. Эзэмших гардан ажилбар:

- 4.6.1 Нярайн тээлтийн нас, биеийн жингээс хамаарч дулаацуулах тоног төхөөрөмж ашиглах, ажиллуулах
- 4.6.2 Амьсгалах боломжийг хангаж амьсгалын дээд замаас соруулах
- 4.6.3 Хүчилтөрөгч эмчилгээ хийх
- 4.6.4 Мөгөөрсөн хоолойд гуурс тавих, мөгөөрсөн хоолойгоос соруулах,
- 4.6.5 Нярайн амьсгалыг удирдах (Амбу хүүдий, урсгалаар тэлэгддэг хүүдий, Neo-Puff аппарат, амьсгалын замд тасралтгүй эерэг даралт өгөх аппарат, амьсгалын аппарат)
- 4.6.6 Нярайн амьсгалыг инвазив бус аргаар удирдах
- 4.6.7 Хүйн судсанд тариа хийх, гуурс тавих, шинжилгээ авах
- 4.6.8 Захын болон том судас, төвийн судсанд тариа хийх, гуурс тавих, шинжилгээ авах
- 4.6.9 Хэл дарагч (воздуховод) тавих
- 4.6.10 Мөгөөрсөн хоолойгоор эм бэлдмэл хийх
- 4.6.11 Цээжний шахалт хийх
- 4.6.12 Фотоэмчилгээ хийх



- 4.6.13 Тархи нугасны шингэн авах
- 4.6.14 Ходоод, давсагт гуурс тавих
- 4.6.15 Плеврийн хатгалт хийх
- 4.6.16 Цус, цусан бүтээгдэхүүн сэлбэх
- 4.6.17 Цус сольж сэлбэх мэс ажилбар, цус хэсэгчилэн сольж сэлбэх
- 4.6.18 Сурфактант эмчилгээ хийх
- 4.6.19 Нярайд түнхний мултрал ба дутуу хөгжил, сонсголын эмгэг илрүүлэх
- 4.6.20 Нярайн нүдний торлогийн эмгэг, бодисын солилцооны төрөлхийн зарим эмгэгийг илрүүлэх

**Тав. Нярайн тусламж үйлчилгээнд хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж**

5.1 Нярайн эрчимт эмчилгээний тасаг/палат

- Амьсгалын аппарат
- Амьсгалын замд тасралтгүй эерэг даралт өгөх аппарат, иж бүрдлийн хамт
- Амбу хүүхдий ба урсгалаар тэлэгддэг хүүхдий, хошуувчууд
- Сэхээн амьдруулах эмчилгээний иж бүрдэл
- Сэхээн амьдруулах ширээ
- Инкубатор
- Монитор, мониторийн наалт, даралтын аппарат, нярайн даралтын манжет
- Ларингоскоп № 0 ба 1
- Салиа соруулагч аппарат
- Пульсоксиметр
- Дуслын автомат тариур ба шахуурга
- Нэг удаагийн эмнэлгийн хэрэгслүүд (дуслын тариурын гуурс, хүчилтөрөгчийн гуурс маск, амьсгалын ба амьсгалын замд тасралтгүй эерэг даралт өгөх аппаратын гуурс, зүү тариур, захын ба төвийн судасны гуурс, хооллох гуурс, соруулах гуурс, хэл дарагч, хөвөн, самбай, боолтын материал, наалт, тархи-нугасны шингэн авах иж бүрдэл, хайч, хүйн хавчаар, хүйн гуурс, шээс цуглуулах уут, шээс авах гуурс, стомын уут, гэдэсний хий гаргах гуурс, зажим, пинцет, бөөр хэлбэрийн сав г.м.)
- Нярайн эмчилгээнд хэрэглэх эм тариа, дуслын шингэнүүд
- Эм эмнэлгийн хэрэгслийн шүүгээ
- Халууны шил
- Утлагын аппарат
- Фотоаппарат
- Электрон жин
- Билирубины төвшрүүлгийг арьсанд хэмжих багаж
- Глюкометр аппарат, тест
- Хүчилтөрөгчийн болон агаарын төхөөрөмж /ханын/
- Хүчилтөрөгч агаар холигч аппарат
- Зөөврийн инкубатор
- Нярайн ор
- Өлгий, даавуу, хөнжил, живх
- Негатоскоп
- Зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппарат /эмнэлэгт/
- Шингэн эм бэлдмэлийг халаах төхөөрөмж
- Зөөврийн дулаацуулах төхөөрөмж ба гудас
- Зөөврийн гэрэлтүүлэгч
- Нян устгах зөөврийн гэрэл

- Ханын термометр
- Сүү саагч төхөөрөмж
- Хөргөгч
- Мэдрэгч бүхий савтай шингэн саван ба гар ариутгагч уусмал, гар арчих цаас
- Тарианы тэргэнцэр
- Эмнэлгийн тоног төхөөрөмж, эм хэрэгсэл тавих тэргэнцэр
- Ажилбарын ширээ
- Ариутгалын уусмал
- Хэт авиан аппарат, гель
- Том цаг

## 5.2 Нярайн эмгэг судлал, дутуу нярайн тасаг/палат

- Хүчилтөрөгчийн ханын төхөөрөмж болон хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат
- Нярайн ор /дугуйтай/
- Өлгий, даавуу, хөнжил, живх
- Дулаацуулах ширээ, дулаацуулах төхөөрөмж, халаах гудас
- Инкубатор
- Зөөврийн инкубатор
- Өлгий вандан
- Амбу хүүдий ба урсгалаар тэлэгддэг хүүдий, хошуувчууд
- Сэхээн амьдруулах эмчилгээний иж бүрдэл
- Ларингоскоп № 0, 1
- Салиа соруулагч аппарат
- Пульсоксиметр
- Монитор, мониторын наалт, даралтын аппарат, нярайн даралтын манжет
- Дуслын автомат тариур ба шахуурга
- Нэг удаагийн эмнэлгийн хэрэгслүүд (дуслын тариурын гуурс, хүчилтөрөгчийн гуурс маск, зүү тариур, захын ба төвийн судасны гуурс, хооллох гуурс, соруулах гуурс, хэл дарагч, хөвөн, самбай, боолтын материал, наалт, тархи-нугасны шингэн авах иж бүрдэл, хайч, хүйн хавчаар, хүйн гуурс, шээс цуглуулах уут, шээс авах гуурс, стомын уут, гэдэсний хий гаргах гуурс, зажим, пинцет, бөөр хэлбэрийн сав г.м.)
- Нярайн эмчилгээнд хэрэглэх эм тариа, дуслын шингэнүүд
- Эм эмнэлгийн хэрэгслийн шүүгээ
- Халууны шил
- Асаргаа сувилгааны иж бүрдэл
- Утлагын аппарат
- Фотоаппарат
- Хэт авиан аппарат, гель
- Электрон жин
- Билирубины төвшрүүлгийг арьсанд хэмжих багаж
- Глюкометр аппарат, тест
- Хүчилтөрөгч агаар холигч аппарат
- Нян устгах зөөврийн гэрэл
- Шингэн эм бэлдмэлийг халаах төхөөрөмж
- Негатоскоп
- Зөөврийн гэрэлтүүлэгч
- Ханын термометр
- Сүү саагч төхөөрөмж
- Хөргөгч

- Мэдрэгч бүхий савтай шингэн саван ба гар ариутгагч уусмал, гар арчих цаас
- Тарианы тэргэнцэр
- Эмнэлгийн тоног төхөөрөмж, эм хэрэгсэл тавих тэргэнцэр
- Ажилбарын ширээ
- Ариутгалын уусмалууд

### **5.3 Нярайг тээвэрлэх түргэн тусламжийн машинд байх эм,эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж**

- Зөөврийн инкубатор /амьсгалын аппарат, монитор, пульсоксиметр аппараттай тоноглогдсон/
- Дулаацуулах төхөөрөмж, гудас
- Пульсоксиметр
- Хүчилтөрөгчийн баллон
- Амбу хүүхдий, хошуувчууд
- Салиа соруулагч аппарат
- Дуслын автомат тариур
- Сэхээн амьдруулах эмчилгээний иж бүрдэл /чемодан, цүнх/
- Ларингоскоп № 0, 1
- Нэг удаагийн эмнэлгийн хэрэгслүүд (дуслын тариурын гуурс, хүчилтөрөгчийн гуурс маск, зүү тариур, захын судасны гуурс, хооллох гуурс, соруулах гуурс, хэл дарагч, хөвөн, самбай, боолтын материал, наалт, хайч, хүйн хавчаар, шээс авах гуурс, гэдэсний хий гаргах гуурс, зажим, пинцет, бөөр хэлбэрийн сав г.м.)
- Эм тариа, дуслын шингэнүүд
- Халууны шил
- Өлгий, даавуу, хөнжил, живх
- Халдваргүйтгэлийн бодисууд

### **6.Нярайг шилжүүлэх, тээвэрлэх**

#### **6.1 Нярайг шилжүүлэх**

- 6.1.1** Нярайг шилжүүлэх асуудлыг ЭМС-ын 2018 оны 256 тоот тушаал "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс иргэнийг эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх эмнэлэгт илгээх журам"-ыг баримтлан шилжүүлнэ.
- 6.1.2** Нярай хүүхдийн биеийн байдал, өвчин эмгэгийн явц, хүндрэх эрсдэл, төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээ шаардлагатай эсэхийг харгалзан анхан шатны эрүүл мэндийн байгууллагаас дараагийн шатлалд шилжүүлнэ.
- 6.1.3** Нярайг шилжүүлэх тухай шилжиж очих байгууллагад урьдчилан мэдэгдэж, хүлээж авах бэлтгэл хангуулсан байна.
- 6.1.4** Нярайн биеийн байдал, тээвэрлэх явцад гарч болох хүндрэлүүдийг урьдчилан тооцож, дараагийн шатлалын эмнэлэгт очоод тусламж авч эмчлэгдэх боломжийг гол үндэс болгоно.
- 6.1.5** Мэс заслын тусламж шаардлагатай нярайд төрөлжсөн нарийн мэргэжлийн эмчийн зөвлөгөөг телемедицин ба утсаар авсны дагуу нярайг шилжүүлэх эсвэл орон нутагт эмчилгээг үргэлжлүүлэхийг шийднэ.
- 6.1.6** Шилжүүлэхийн өмнө нярайд шаардлагатай тусламж үйлчилгээг үзүүлж биеийн байдлыг тогтворжуулна. Үүнд: орчих цус хомсдол, хүнд цус багадалт, ус-эрдсийн тэнцвэрт байдал, цусны тэнцвэрт байдал, амьсгалын цочмог дутагдал, зүрх судасны цочмог дутагдал зэргийг тэгшитгэх эмчилгээ хийнэ.
- 6.1.7** Эмчлэгч эмч, ажлын бус цагаар жижүүрийн эмч нярайг дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэх болсон тухай эх, эцэг эсвэл асран хамгаалагчид

тайлбарлан мэдээлэх ба тээвэрлэх явцад болон шилжиж очсоны дараа учирч болох эрсдлийг тайлбарлаж хэлсэн байна.

**6.1.8** Эмнэлгийн байгууллагын шатлал хооронд өвчтөн шилжүүлэхдээ шилжүүлж буй эмч "Нярайн шилжүүлгийн маяг"-ын асуулт бүрийг бөглөж шилжүүлнэ.

**6.1.9** Хүлээн авах байгууллага нь шилжин ирж буй нярайг хүлээн авах бэлтгэлийг хангасан байна.

## **6.2** Нярайг тээвэрлэх

**6.2.1** Нярайг тээвэрлэхийн өмнө тээвэрлэх аргаа сонгож, аюулгүй тээвэрлэлтийг зохион байгуулна.

**6.2.2** Өвчтэй нярайг нярайн эмч эсвэл нярайд яаралтай болон амилуулах тусламж үзүүлэх чадвар бүхий сургалтанд хамрагдсан, аппарат тоног төхөөрөмжийг ажиллуулах туршлагатай эмч /сувилагчийн хамт багаар/ тээвэрлэнэ.

**6.2.3** Тээвэрлэх багийн гишүүд өвчтөнг тээвэрлэсэнтэй холбоотой гарах эрсдэл хүндрэлийн /даарах, биеийн халуун нэмэгдэх, амьсгал дамжилт алдагдах, цусны эргэлт алдагдах, сахар багадалт, судсанд тавьсан уян гуурс гарах, мөгөөрсөн хоолойн гуурс сугарах, цусархаг хамшинж/ эмгэг физиологийн өөрчлөлтүүдийг мэддэг, түргэн тусламжийн машинд болон онгоцонд ажиллах чадвартай байна. Шаардлагатай тохиолдолд тээвэрлэлтийн явцад цусны сахар багасалтаас сэргийлж судсаар шингэн сэлбэх, эсвэл эхийн сүүгээр хооллоно.

**6.2.4** Жирэмсэн эх ба ураг, нярайд өндөр эрсдэлтэй эмгэг оношлогдсон тохиолдолд аль болохоор жирэмсэн эхийг /ургийг эхийн хэвлийд байхад тээвэрлэх/ дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэн төрүүлэх.

**6.2.5** Нярайг тээвэрлэх замын зай, тээвэрлэлтийн хугацаанаас хамаарч тээврийн хэрэгслийг сонгоно /газраар болон агаараар/.

**6.2.6** Тээвэрлэлтийн үеийн хуудсыг хөтлөн тээвэрлэсэн цаг, биеийн байдалд гарсан өөрчлөлт, мониторын үзүүлэлтүүдийг тэмдэглэнэ.

**6.2.7** Тээвэрлэж авчирсан нярайг тасгийн эрхлэгчид, ажлын бус цагаар жижүүрийн эмчид "гараас гарт" хүлээлгэн өгнө.

**6.2.8** Нярайг тээвэрлэх тухай мэдээлийг эх, эцэг эсвэл асран халамжлагчид өгч, тэдний аль нэгтэй хамт тээвэрлэнэ.

Эрүүл Мэндийн сайдын 2018 оны 12  
дугаар сарын 28-ны өдрийн А/Б/С тоот  
тушаалын 2 дугаар хавсралт



**Нярайн шилжүүлгийн маягт**

Эмнэлгийн нэр ..... Төрсөн төрөх/амаржих газар.....  
Эхийн овог нэр..... Нярайн нэр/орны  
дугаар.....

Шилжүүлж буй  
зорилго:.....

Нярайн нас ..... хоног, Гэрийн хаяг ..... Утасны  
дугаар.....

Тээлтийн нас ..... д/х, Төрсөн 20.....он.....сар.....өдөр, Төрсөн жин ..... гр, урт .....

Хүйс эр / эм, Апгарын үнэлгээ 1 мин ..... 5 мин ..... 10 мин ..... 20 мин .....  
Төрөлтийн байдал: Хэвийн, эмгэг, төрөх замаар, кесар хагалгаа/давтан, сэдээлт,  
эрчимжүүлэлт, төрөх хүчний сулрал, ураг орчмын шингэн эрт гарсан, усгүй

Төрөлтийг шийдсэн байдал: Эхийн заалтаар, ургийн заалтаар/ургийн бүтэлт,  
өсөлтийн саатал, цус задрах өвчин,  
.....

Жирэмслэлтийн байдал: эрт үеийн хордлого, хожуу хордлого, манас таталтын  
урьдал/хүнд хэлбэр, HELLP хамшинж, ихэс түрүүлсэн, ихэс ховхорсон,  
.....

Түрүүлсэн хэсэг: Толгой, өгзөг, хөл, хөндлөн, гар/ хөл/ хүй унжсан  
Эх барихын ажилбар хийсэн/ үгүй: вакуум таталт, эх барихын хавчуур, бусад  
Ураг орчмын шингэн төрлөг эхлэхээс хэдэн цаг/хоногийн өмнө гарсан .....  
Ураг орчмын шингэний байдал: Тунгалаг, шар, ногоон, цустай, үнэртэй, их, бага,  
хэвийн

**Сэхээн амьдруулах эмчилгээ:**

Амбу маск .....мин NeoPuff.....мин

Цээжний шахалт хийсэн нас/цаг .....

Хүйн судсанд хийсэн эмчилгээ  
.....  
.....

Мөгөөрсөн хоолойд гуурс тавьсан/үгүй, Гуурставьсан нас/цаг/хоног .....

CPAP-аар амьсгал удирдсан/үгүй, Удирдсан хугацаа .....хоног.....цаг

Амьсгалыг аппаратаар удирдсан/үгүй, Удирдсан хугацаа .....хоног.....цаг

Сурфактант эмчилгээ хийсэн/үгүй: Сурфактант хийсэн үеийн нярайн нас/цагаар.....

**Хооллолт:** Хөхөө амалсан / амлаагүй Хөхөө амалсан нас/цаг .....

Хооллож эхэлсэн нас/цаг ..... Хооллосон хэлбэр: Хөх, угж, гуурс, тариур /зур/

Одоо хооллож буй хэлбэр Хөх, угж, гуурс, тариур /зур/

Хооллож буй хэмжээ 1 удаад ..... мл, хоногт..... мл

Зунгаг гарсан нас/цаг ....., шээсний гарц хоногт ..... мл

Шилжих үеийн биеийн жин .....гр, Биеийн халуун.....хэм, Амьсгалын тоо .....

Зүрхний цохилтын тоо ....., FiO2 ....., SatO2 .....%, Артерийн даралт .....

**Төрсний дараах нярайн зовиур, биеийн байдал:**

.....  
.....  
.....

**Нярайн шилжих үеийн зовиур, биеийн байдал:**

.....  
.....  
.....  
.....

**Хийсэн шинжилгээ:**

.....  
.....  
.....  
.....

**Хийсэн эмчилгээ:**

Антибиотик:.....

Бусад:

.....  
.....  
.....  
.....

**Төрөх үеийн эхийн онош:**

**Төрөх үеийн нярайн онош:**

**Шилжүүлж буй онош:**

1. Үндсэн онош:

2. Хүндрэлийн онош:

3. Хавсарсан өвчний онош:

Эмчлэгч эмч ....., албан тушаал .....

Шилжүүлж ирсэн эмч ....., албан тушаал.....

20..... он ..... сар ..... өдөр